



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 3 /гурав/ хуулийн этгээдэд “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай тус тус олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШУУД

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн
196 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	БӨҮ ХХК	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /интернэт/	2025.09.18	2030.09.18
2	Интеллигент технологи партнер ХХК	Архангай аймгийн нутаг дэвсгэрт Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /интернэт/	2025.09.18	2030.09.18
3	Ди Би Эс Си ХХК	Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /интернэт/	2025.09.18	2030.09.18

----- оОо -----